



МОНГОЛЫН АМЬСЭН
АКАДЕМИ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН ТАНИЛЦУУЛГА

2022

Улаанбаатар хот
2023 он


ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ийн Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Г.Пүрэвсүрэн

ЧД-ийн Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БАЙР, 401 тоот

Утас: 70113013

70130767

70110767

976-11-310767

51-261125

Цахим хуудас: www.ubstat.mnwww.chingeltei.gov.mn

И-мэйл: chingeltei@nso.mn

ХҮН АМ

Энэ бүлэгт дүүргийн хүн амын өсөлт, нас хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг тусгав. Хүн амын статистикийн мэдээллийн үндсэн эх үүсвэр нь 10 жил тутамд явуулдаг хүн ам, орон сууцны тооллого, хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөний жил бүрийн мэдээ тайлан болно.

Чингэлтэй дүүргийн хүн амд дүүргийн нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат хүн амыг хамруулна.

Хүн амын жилийн дундаж тоог жилийн эхний болон эцсийн хүн амын тооны нийлбэрийг 2-т хувааж тооцно.

Өрх гэж нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд өрх толгойлон амьдарч байгаа эмэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.

Эцэг, эх нь хоёулаа нас барсан хүүхдийг бүтэн өнчин, эцэг, эх хоёрын аль нэг нь нас барсан хүүхдийг хагас өнчинд тооцно.

Төрөлтийн хүйсийн харьцаа нь төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм. Төрөлтийн ерөнхий коэффициент нь 1000 хүнд ногдох тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, илэрхийлнэ.

Төрөлтийн тусгай коэффициент нь нөхөн үржихүйн нас (15-49 нас)-ны 1000 эмэгтэйд ногдох тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн төрөх насны буюу 15-49 насны эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, илэрхийлнэ.



ХҮН АМ, 2022 онд

ᠬᠤᠨ ᠠᠮ

Нийт хүн ам



144 249



73 837

51.2%

70 412

48.8%



Амаржсан эх



2021 3 017

2022 2 577

-14.6% ↓

Насны ангилал



Төрөлт

3 373 3 049 2 202

2020

2021

2022

Нас баралт

725

103

2 602

2020

2021

022



ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТ


Нийслэлийн Чингэлтэй дүүргийн нийт хүн ам 2022 онд 144249 болж, өмнөх оноос 6299 (4.2%) хүнээр буурсан. Дүүргийн хэмжээнд 2022 онд 2935 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оноос 423 (12.6%) хүүхдээр буурсан үзүүлэлтэй байна.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛС, НИЙСЛЭЛ ХОТЫН ХҮН АМЫН ТОО, дүүргээр, оноор

Засаг захиргаа	2017	2018	2019	2020	2021	2022
Монгол Улсын нийт хүн ам	3 131 750	3 186 347	3 197 020	3 357 542	3 409 939	3 368 632
Нийслэлийн дүн	1 417 396	1 444 669	1 466 125	1 597 290	1 539 252	1 596 335
Чингэлтэй	159 051	157 258	148 977	151 203	150 548	144 249
Багануур	28 787	29 512	28 570	29 342	29 433	29 341
Багахангай	4 100	4 399	4 123	4 463	4 459	4 416
Баянгол	221 384	226 869	225 840	231 517	236 385	246 886
Баянзүрх	336 932	343 619	361 689	367 679	383 892	408 797
Налайх	36 911	37 608	37 659	38 690	38 929	39 579
Сонгиохайрхан	322 458	321 150	327 580	335 703	341 540	342 112
Сүхбаатар	138 047	145 335	144 409	144 616	144 542	142 444
Хан-Уул	169 726	178 919	187 278	195 927	209 524	238 511

Чингэлтэй дүүрэгт Нийслэл хотын хүн амын 9.0 хувь, Монгол Улсын хүн амын 4.3 хувь нь байнга оршин сууж байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 8.9 мянган га бөгөөд нэг километр квадрат талбайд 1693 хүн ногдож байна.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, хүйсээр, хувиар, 2022 он



Төрөх үеийн хүйсийн харьцаа 110.1 байгаа нь шинэ төрсөн 100 охин хүүхэд тутамд 110 эрэгтэй хүүхэд ногдож буйг харуулж байна. Уг үзүүлэлтийн улсын дүн 97.1, нийслэлийн дүн 93.6 байна.


Хүн амын дундаж наслалт 2022 онд улсын дундаж 71.1 нийслэлийн дундаж 72.3 байна. Монгол эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.5 байгаа нь эрэгтэй хүний дундаж наснаас 9.42 насаар өндөр байна. Суурин хүн ам гэдэг нь тухайн нутаг дэвсгэрт 183 хоног, түүнээс дээш хугацаагаар байнга оршин сууж буй хүн ам юм.

ХҮСНЭГТ 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО, хороогоор, оноор

Хороо	2017	2018	2019	2020	2021	2022
Дүүргийн дүн	159 051	157 258	148 977	151 203	150 548	144 249
1 -р хороо	3 900	4 232	3 836	4 113	4 040	3 804
2 -р хороо	3 431	3 414	3 597	3 553	3 636	3 399
3 -р хороо	6 060	6 766	6 274	6 273	6 432	6 121
4 -р хороо	5 219	5 118	4 951	4 981	5 258	5 300
5 -р хороо	4 911	5 229	4 743	4 825	4 709	4 626
6 -р хороо	7 523	7 987	8 395	8 320	8 761	9 254
7 -р хороо	13 596	12 834	11 917	12 324	12 460	6 611
8 -р хороо	4 535	4 354	3 882	3 896	3 849	3 658
9 -р хороо	7 247	7 364	6 413	6 607	6 647	6 244
10 -р хороо	8 096	7 946	7 341	7 541	7 433	7 074
11 -р хороо	5 776	5 585	5 377	5 343	5 164	4 863
12 -р хороо	15 665	15 248	14 314	14 638	14 531	6 729
13 -р хороо	8 275	8 203	7 670	7 676	7 446	6 983
14 -р хороо	7 580	7 694	6 850	6 985	6 860	6 461
15 -р хороо	8 945	9 226	8 532	8 658	8 651	8 524
16 -р хороо	12 751	12 202	12 655	12 760	12 356	7 808
17 -р хороо	13 860	13 372	13 299	13 444	13 278	7 907
18 -р хороо	9 784	9 082	8 300	8 501	8 320	7 865
19 -р хороо	11 897	11 402	10 631	10 765	10 717	7 456
20-р хороо	-	-	-	-	-	5 223
21-р хороо	-	-	-	-	-	7 027
22 -р хороо	-	-	-	-	-	4 021
23 -р хороо	-	-	-	-	-	4 509
24 -р хороо	-	-	-	-	-	2 782


Хүн амын тооны дундаж 6010.5 байгаа бол хамгийн их хүн амтай 6 дугаар хороонд 9254 хүн байнга оршин сууж байгаа нь дүүргийн нийт хүн амын 6.4 хувийг эзэлж байна.

Зураг 2. Хороодын хүн амын тоо, хороогоор, 2022 он



Сүүлийн жилүүдэд Нийслэлийн хэмжээнд орон сууцны хороолол, хотхон ихээр баригдаж байгаа боловч Чингэлтэй дүүргийн хороодод томоохон орон сууцны хороолол, хотхон баригдахгүй байгаа нь хүн хүн амын өсөлтийн хурд саарахад голлон нөлөөлж байна.

ЗУРАГ 3. ХҮН АМЫН ТОО, жилийн дундаж өсөлт, оноор



Дүүргийн нийт хүн амын 70412 буюу 48.8 хувь нь эрэгтэй, 73837 буюу 51.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 3. ХОРООДЫН ХҮН АМЫН ТОО, хүн ам зүй ачаалал, хороогоор, 2022 он

Хороод	Нийт хүн ам	Хүн ам зүйн ачаалал	
		Эрэгтэй	Эмэгтэй
Дүүргийн дүн	144 249	70 412	73 837
1-р хороо	3 804	1 711	2 093
2-р хороо	3 399	1 566	1 833
3-р хороо	6 121	2 755	3 366
4-р хороо	5 300	2 390	2 910
5-р хороо	4 626	2 155	2 471
6-р хороо	9 254	4 274	4 980
7-р хороо	6 611	3 246	3 365
8-р хороо	3 658	1 802	1 856
9-р хороо	6 244	3 084	3 160
10-р хороо	7 074	3 501	3 573
11-р хороо	4 863	2 448	2 415
12-р хороо	6 729	3 350	3 379
13-р хороо	6 983	3 433	3 550
14-р хороо	6 461	3 223	3 238
15-р хороо	8 524	4 176	4 348
16-р хороо	7 808	3 971	3 837
17-р хороо	7 907	3 971	3 936
18-р хороо	7 865	3 882	3 983
19-р хороо	7 456	3 788	3 668
20-р хороо	5 223	2 610	2 613
21-р хороо	7 027	3 432	3 595
22-р хороо	4 021	2 006	2 015
23-р хороо	4 509	2 240	2 269
24-р хороо	2 782	1 398	1 384

Хүн ам зүйн ачаалал 2022 онд 58.1 болж өмнөх оноос 0.6 хувиар буурсан байна. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн тутамд 50 хүүхэд, 8 өндөр настан ногдож байгааг харуулж байна. Уг үзүүлэлтийг хорооны түвшинд авч үзвэл 24 дүгээр хороонд хамгийн өндөр буюу 96.8 хувь, байна. Дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6 хороод нь Нийслэл хотын төв хэсэгт байрладаг бөгөөд хүн ам зүйн ачааллын хувьд өндөр үзүүлэлттэй гарсан байна. Орон сууцны хороод нь Нийслэл хотын анхны орон сууцны барилгууд байрладаг ба өндөр настнууд байрандаа тогтвортой амьдардаг нь нөлөөлж байна. Мөн сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муутай үед хотын төвийн сургуульд хүүхдээ сургах гэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн нөлөөлж байна.


Төрөлт нас баралтын зөрүүгээр хүн амын тоо 2362 хүнээр нэмэгдсэн байна. Ердийн цэвэр өсөлтийн коэффициент 14.3 промил байгаа нь 1000 хүн ам тутмын 14 хүн нь шинээр мэндэлсэн хүүхэд байна. Иргэний бүртгэлийн шинэ хуулийн дагуу тухайн иргэн шилжин явж буй тохиолдолд үндсэн баг, хорооноос хасалт хийгдэхгүй болсонтой холбоотойгоор шилжин явж буй иргэний мэдээлэл бүртгэгдэхгүй болсон учраас шилжилт хөдөлгөөний мэдээлэл тооцоонд ороогүй болно.

ХҮСНЭГТ 4. ХҮН АМЫН ЕРДИЙН БОЛОН МЕХАНИК ӨСӨЛТ, өсөлтийн коэффициент, оноор

Он	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент	Шилжин ирсэн	Шилжин явсан	Механик өсөлт	Шилжих хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент
2017	3 764	960	2 804	17.7	9 082	14 152	-5 070	-32.0
2018	3 756	857	2 899	18.4	8 707	13 847	-5 140	-32.5
2019	3 863	896	2 967	17.6	9 235	-	-	-
2020	3 591	821	2 770	18.4	7 447	-	-	-
2021	3 358	1 195	2 163	14.3	7 056	-	-	-
2022	2 935	573	2 362	16.0	2 484	-	-	-

Зураг 3-аас харахад 2021 онд уг үзүүлэлт төрөлт нас баралтын зөрүүгээр 14 хүн нэмэгдэж, өсөлтийн хурд 1.5 хувиар өсөж байсан бол 2022 онд төрөлт нас баралтын зөрүүгээр 16 хүн нэмэгдэж, өсөлтийн хурд 0.6 хувиар өссөн байна.


ЗУРАГ 4. ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ердийн цэвэр өсөлтийн коэффициент, 2010-2022 он



Хүн амын нас хүйсийн суварга нь нас хүйсийг ерөнхий бүтцээр нь хуваарилан харахад хамгийн тохиромжтой арга юм. Графикаас харахад 2010 оны хүн амын бүтэц 20-39 насанд өргөссөн нь тухайн үед ажиллах хүчний таатай буюу цонх үе байв, харин 1990-2005 онд төрөлт буурч 5-19 насны хүн амын жин буурч байжээ.

Харин 2021 оны хүн амын бүтцэд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэн нөлөөлж 0-9 насны хүн амын тоо нэмэгдсэн байна. Мөн 25-34 насны хүн ам харьцангуй их байгаа нь хөдөлмөрийн насны залуучууд дийлэнх хэсгийг эзэлж, хөдөлмөр эрхлэлтийн таатай үе үргэлжилж байгааг харуулж байна.

ЗУРАГ 5. ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН СУВАРГА, 2021, 2022 он



ХҮСНЭГТ 5. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр, 2017-2022 он

Насны ангилал	2019		2020		2021		2022	
	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй
Нийт дүн	80 779	148 977	151 203	77 633	150 548	77 198	144 249	73 837
0 нас	3 231	1 609	3 414	1 688	3 125	1 653	2 620	1 261
1-4	13 963	6 718	13 634	6 585	13 231	6 805	12 001	5 857
5-9 нас	17 188	8 438	17 782	8 732	17 606	9 016	16 251	7 902
10-14 нас	12 145	5 910	13 173	6 408	14 116	6 891	14 214	6 931
15-19 нас	9 148	4 506	8 947	4 396	8 927	4 335	9 213	4 459
20-24 нас	9 455	4 804	9 298	4 708	9 274	4 723	8 854	4 405
25-29 нас	11 942	6 048	11 010	5 622	10 046	5 092	9 110	4 565
30-34 нас	14 381	7 249	14 589	7 293	14 199	7 105	12 861	6 439
35-39 нас	11 444	5 796	11 912	6 017	12 179	6 167	11 795	5 877
40-44 нас	10 211	5 260	10 243	5 318	10 211	5 212	9 890	5 056
45-49 нас	8 983	4 735	9 232	4 837	9 294	4 935	8 968	4 740
50-54 нас	7 909	4 286	8 107	4 383	7 975	4 271	7 855	4 210
55-59 нас	7 053	3 931	7 066	3 950	7 190	4 027	7 004	3 938
60-64 нас	4 971	2 868	5 387	3 118	5 543	3 221	5 682	3 279
65-69 нас	2 800	1 677	2 971	1 789	3 277	1 981	3 475	2 103
70, түүнээс дээш нас	4 153	2 604	4 438	2 789	4 355	2 750	4 456	2 815

Чингэлтэй дүүргийн нийт хүн амын 12121 (8.4%) нь цэцэрлэгийн насны хүүхэд байгаа бол эдгээр хүүхдийн 9593 (78.8%) нь цэцэрлэгт хамрагдаж байна. Харин нийт хүн амын 35002 (24.3%) нь сургуулийн насны хүүхэд байгаа бол эдгээр хүүхдийн 30477 (87.1%) хувь нь сургуульд хамрагдаж байна. Тэтгэврийн насны хүний тоо 19827 болж өмнөх оны мөн үеэс 6713 (51.2%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 6. ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ АНГИЛАЛ, хороогоор, 2022 он

Хороо	Цэцэрлэгийн насны хүүхэд (2-5 нас)		Сургуулийн насны хүүхэд (6-18 нас)		Өндөр настан (эр-60+, эм-55+)	
	хүүхэд (2-5 нас)	эмэгтэй	хүүхэд (6-18 нас)	эмэгтэй	хүүхэд (эр-60+, эм-55+)	эмэгтэй
Дүүргийн дүн	12 121	5 888	35 002	17 101	19 827	11 658
1-р хороо	256	121	1 031	482	647	410
2-р хороо	256	119	926	434	527	334
3-р хороо	474	227	1 691	821	972	601
4-р хороо	414	200	1 260	643	879	557
5-р хороо	342	175	1 044	522	775	496
6-р хороо	811	392	2 393	1 184	1 176	732
7-р хороо	608	310	1 488	735	849	481
8-р хороо	307	159	798	391	583	327
9-р хороо	524	267	1 373	669	883	530
10-р хороо	595	300	1 681	821	865	507
11-р хороо	348	161	1 184	572	699	398
12-р хороо	591	287	1 578	762	938	548
13-р хороо	633	322	1 645	794	960	550
14-р хороо	558	248	1 505	738	902	523
15-р хороо	795	402	2 052	1 010	1 070	611
16-р хороо	644	307	1 806	846	611	601
17-р хороо	655	307	1 912	965	601	632
18-р хороо	621	308	1 866	921	1 059	620
19-р хороо	594	274	1 934	927	975	530
20-р хороо	498	228	1 287	616	563	316
21-р хороо	685	328	1 766	894	709	419
22-р хороо	347	165	1 035	522	453	258
23-р хороо	382	190	1 094	525	607	351
24-р хороо	183	91	653	307	571	326

➤ ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД

Нийгмийн зарим үзүүлэлтийн судалгаагаар 2022 онд бүтэн өнчин 166 хүүхэд бүртгэгдсэн нь дүүргийн 0-17 насны нийт хүүхдийн 0.3 хувийг эзэлж байна. Бүтэн өнчин хүүхдийн 72 (43.4%) нь эмэгтэй хүүхэд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо өмнөх оноос 16 (14.5%) хүүхдээр өссөн байна.

2022 онд хагас өнчин 1756 хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оноос 168 (10.6%) хүүхдээр өссөн байна. Дүүргийн 0-17 насны нийт хүүхдийн 3.4 хувь нь хагас өнчин хүүхэд байна. Үүнээс 839 (47.8%) нь эмэгтэй хүүхэд байна.


ЗУРАГ 6. ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, оноор



➤ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ

Өрх толгойлсон хүний тоо 2296 болж өмнөх оны мөн 204 (8.2%) хүнээр буурсан байна. Өрх толгойлсон нийт эцэг, эхийн 1395 (60.8%) нь 18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эх байна.

ЗУРАГ 7. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, 2021, 2022 он



Нийгмийн зарим үзүүлэлтийн 2022 оны судалгаагаар дүүргийн хэмжээнд алдарт эхийн одонтой 7936 эх байгаагийн 1995 (25.1%) нь алдарт эхийн I одонтой эх, 5941 (74.9%) алдарт эхийн II одонтой эх байна.

ХҮСНЭГТ 7. АЛДАРТ ЭХИЙН ОДОНТОЙ ЭХИЙН ТОО, ХҮҮХДЭЭР, ХОРООГООР

Захиргаа	Алдарт эхийн одонтой нийт		I зэргийн одон		II зэргийн одон	
	Эхийн тоо	Хүүхдийн тоо	Эхийн тоо	Хүүхдийн тоо	Эхийн тоо	Хүүхдийн тоо
Дүүргийн дүн	7 936	36 912	1 995	11 728	5 941	25 184
1-р хороо	155	588	24	152	131	436
2-р хороо	154	533	28	118	126	415
3-р хороо	267	1 085	33	198	234	887
4-р хороо	189	88	42	238	147	646
5-р хороо	202	835	42	230	160	605
6-р хороо	320	1 343	51	333	269	1 010
7-р хороо	370	2 166	75	648	295	1 518
8-р хороо	222	1 030	56	348	166	682
9-р хороо	352	1 692	69	551	283	1 141
10-р хороо	406	1 899	114	625	292	1 274
11-р хороо	291	1 360	73	455	218	905
12-р хороо	448	1 870	223	790	225	1 080
13-р хороо	449	2 215	118	763	331	1 452
14-р хороо	415	2 008	103	673	312	1 335
15-р хороо	425	1 823	120	695	305	1 128
16-р хороо	771	3 463	162	1 080	609	2 383
17-р хороо	380	1 725	69	398	311	1 327
18-р хороо	332	1 596	66	422	266	1 174
19-р хороо	409	1 963	161	768	248	1 195
20-р хороо	235	803	12	109	223	694
21-р хороо	413	1 595	93	608	320	987
22-р хороо	195	839	54	273	141	566
23-р хороо	249	1 168	46	289	203	879
24-р хороо	287	2 429	161	964	126	1 465

➤ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 4063 болж өмнөх оны мөн үеэс 128 (3.3%) хүнээр өссөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 1793 (44.1%) нь эмэгтэйчүүд, 515 (12.8%) нь 0-17 насны хүүхэд, 240 (5.9%) нь 65 түүнээс дээш насны хүн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаанаар авч үзвэл 1904 буюу 46.9 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, 1845 буюу 45.4 хувь нь олдмол өвчнөөр, 314 буюу 7.7 хувь нь осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Дүүргийн 0-17 насны хүүхдийн 515 (12.8%) нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өвчний төрлөөр авч үзвэл 34 (0.8%) нь харах эрхтний өөрчлөлттэй, 31 (0.8%) нь сонсголын бэрхшээлтэй, 28 (0.7%) нь ярианы бэрхшээлтэй, 90 (2.2%) нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 90 (2.2%) нь сэтгэцийн эмгэгтэй, 87 (2.1%) нь хавсарсан согогтой, 155 (3.8%) нь бусад өвчний төрөлд хамрагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний 1693 (41.7%) нь нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон, 372 (22.0%) нь хөдөлмөр эрхэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1356 (33.4%) нь байнгын асаргаанд байгаа ба 648 (47.8%) нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-17 насны 515 хүүхдийн 394 (76.5%) нь байнгын асаргаанд байна.

Хүснэгт 8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, өвчний төрөл, шалтгаанаар, 2022

	Хөгжлийн бэрхшээлийн төрөл									
	Бүгд	Эмэгтэй	Хөдөлмөр эрхэлдэг	Төрөлхийн	Олдмол	Өвчнөөр		Осол гэмтлээр		
						Ердийн өвчин	Мэргэжлээс шалтгаалсан өвчин	Зам тээврийн осол	Үйлдвэрлэлийн осол	Ахуйн осол
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	4 063	1 793	372	1 904	2 159	1 727	118	86	84	144
0-17 нас	515	198	2	399	116	112	-	-	-	4
18, түүнээс дээш	3 548	1 595	370	1 505	2 043	1 615	118	86	84	140
Харааны бэрхшээлтэй	401	177	52	160	241	195	10	3	14	19
0-17 нас	34	23	-	29	5	5	-	-	-	-
18, түүнээс дээш	367	154	52	131	236	190	10	3	14	19
Ярианы бэрхшээлтэй	283	105	24	214	69	67	1	1	-	-
0-17 нас	28	12	-	22	6	6	-	-	-	-
18, түүнээс дээш	255	93	24	192	63	61	1	1	-	-
Сонсголын бэрхшээлтэй	338	165	65	165	173	145	20	2	3	3
0-17 нас	31	11	-	25	6	6	-	-	-	-
18, түүнээс дээш	307	154	65	140	167	139	20	2	3	3
Хөдөлгөөний бэрхшээлтэй	618	279	44	263	355	190	10	49	37	69
0-17 нас	90	34	1	76	14	13	-	-	-	1
18, түүнээс дээш	528	245	43	187	341	177	10	49	37	68
Сэтгэцийн бэрхшээлтэй	773	365	42	515	258	223	14	7	5	9
0-17 нас	90	29	1	84	6	6	-	-	-	-
18, түүнээс дээш	683	336	41	431	252	217	14	7	5	9
Хавсарсан бэрхшээлтэй	422	183	24	187	235	218	10	5	1	1
0-17 нас	87	30	-	48	39	39	-	-	-	-
18, түүнээс дээш	335	153	24	139	196	179	10	5	1	1
Бусад бэрхшээлтэй	1 228	519	121	400	828	689	53	19	24	43
0-17 нас	155	59	-	115	40	37	-	-	-	3
18, түүнээс дээш	1 073	460	121	285	788	652	53	19	24	40



Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, өвчний төрөл, насны бүлгээр, 2022

Үзүүлэлт	Хөгжлийн бэрхшээлийн төрөл									
	Бүгд	Эмэгтэй	Хөдөлмөр эрхэлдэг	Төрөлхийн	Олдмол	Өвчнөөр		Осол гэмтлээр		
						Ердийн өвчин	Мэргэжлээс шалтгаалсан өвчин	Зам тээврийн осол	Үйлдвэрлэлийн осол	Ахуйн осол
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	4 063	1 793	372	1 904	2 159	1 727	118	86	84	144
0-4 нас	67	22	1	49	18	18	-	-	-	-
5-9 нас	184	71	-	145	39	36	-	1	-	3
10-14 нас	173	69	1	126	47	47	-	-	-	-
15 нас	43	22	-	39	4	3	-	-	-	1
16 нас	26	8	-	22	4	4	-	-	-	-
17 нас	22	6	-	18	4	4	-	-	-	-
18 нас	38	13	1	25	13	8	-	-	1	4
19 нас	31	14	2	25	6	5	-	-	-	1
20-34 нас	723	298	80	408	315	257	15	17	11	15
35-64 нас	2 574	1 188	284	990	1 584	1 240	97	67	69	111
65, түүнээс дээш нас	182	82	3	57	125	105	6	2	3	9

Ойлголт, тодорхойлолт

Хүн амын бүртгэл: Тухайн газар нутагт тодорхой цаг хугацааны дотор гарсан хүн ам зүйн үзэгдэл болон хүн амын тоог бүртгэж авах үйл явц болно.¹

Хүн амын ердийн хөдөлгөөний статистик: Хүн амын ердийн хөдөлгөөнтэй холбоотой бүх үзэгдэл, тухайлбал төрөлт, нас баралт, шилжин ирэгчид болон шилжин явагчдын тоо, гэрлэлт, гэр бүл салалтын тоо, тэдгээрийг үндэслэн тооцдог харьцуулсан үзүүлэлтүүдээс бүрдэнэ.¹

Хүн ам зүйн шилжилт: Хүн амын төрөлт болон нас баралтын өндөр түвшинээс нам түвшинд шилжиж буй динамик шилжилт юм. Нас баралтын бууралт нь голдуу төрөлтийн бууралтаас түрүүлж явагддаг бөгөөд энэ нь шилжилтийн хугацааны туршид хүн амын огцом өсөлтийг бий болгодог.¹

Хүн амын тоо: Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.¹

Суурин хүн ам: Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг хэлнэ.²

Бэлэн хүн ам: Тооллого явуулж буй үед тухайн нутагт дэвсгэрт оршин сууж байгаа нийт хүн амыг (байнга болон түр хугацаагаар амьдарч байгаагаас үл хамаарч) хэлнэ. Бэлэн хүн амыг хүн ам, орон сууцны тооллогоор 10 жилд нэг удаа тодорхойлно.²

Жилийн эхний хүн ам: Тайлант оны эхэнд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.²

Жилийн эцсийн хүн ам: Тайлант оны эцэст, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.²

$$P(n) = P_0 + (B - D) + (In - Out)$$

P(n)-	Хугацааны эцэс дэх хүн амын тоо
P ₀ -	Оны эхний хүн ам
B-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх нийт төрөлт
D-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх нийт нас баралт
In-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжин ирэлт
Out-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжин явалт

Хүн амын жилийн дундаж тоо: Тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ.²

$$XA_{(дун)} = \frac{XA_{(ж.эх)} + XA_{(ж.эц)}}{2}$$

XA_(дун) - Хүн амын жилийн дундаж тоо

XA_(ж.эх) - Жилийн эхний хүн амын тоо

XA_(ж.эц) - Жилийн эцсийн хүн амын тоо

Хүн амын өсөлт, бууралт: Тодорхой хугацааны туршид хүн амын тооны эерэг өөрчлөлтийг хүн амын өсөлт, сөрөг өөрчлөлтийг хүн амын бууралт гэнэ.³

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.³

Тооцох арга зүй: Тухайн онд төрсөн нийт хүүхдийн тооноос нас барсан нийт хүний тоог хасч тооцно. Төрөлт, нас баралтын тооноос шалтгаалж энэ үзүүлэлт нь эерэг, сөрөг аль нь ч байж болно.

$$E\Theta_{(XA)} = TT - HBT$$

$E\Theta_{(XA)}$ - Хүн амын ердийн цэвэр өсөлт

TT - Төрсөн нийт хүүхдийн тоо

HBT - Нас барсан нийт хүний тоо

Хүн амын ердийн цэвэр өсөлт (бууралт)-ийн коэффициент: Хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр тухайн жилийн хүн ам өссөн (буурсан)-ийг харуулах коэффициент бөгөөд түүнийг суурин хүн амд эзлэх хувиар илэрхийлнэ.¹

Тооцох арга зүй: Тухайн онд төрсөн нийт хүүхдийн тооноос нас барсан нийт хүний тоог хасч, хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ. Төрөлт, нас баралтын тооноос шалтгаалж энэ үзүүлэлт нь эерэг, сөрөг аль нь ч байж болно.

$$E\Theta K_{(XA)} = \frac{TT - HBT}{XA_{(дун)}} * 1000$$

$E\Theta K_{(XA)}$ - Хүн амын ердийн цэвэр өсөлт /бууралтын коэффициент

TT - Төрсөн нийт хүүхдийн тоо


HBT - Нас барсан нийт хүний

тоо $XA_{(дун)}$ - Хүн амын жилийн

дундаж тоо

ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ-2022 ОН

ᠡᠷᠬᠡᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ 2022






ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 2022 онд 37246 өрх оршин сууж, байна. Өрхийн тоо 1992 оноос 20561 өрхөөр буюу 1.2 дахин өссөн бол өмнөх оноос 1167 (3.0%) өрхөөр буурсан байна. Чингэлтэй дүүрэгт Монгол Улсын нийт өрхийн 4.0 хувь, Нийслэл хотын нийт өрхийн 8.6 хувь нь байнга оршин

сууж байна.

ХҮСНЭГТ 10. МОНГОЛ УЛС, НИЙСЛЭЛ ХОТЫН ӨРХИЙН ТОО, дүүргээр, оноор

Захиргаа	2017	2018	2019	2020	2021	2022
Монгол Улсын нийт өрх	885 639	894 496	897 427	908 712	920 165	941 548
Нийслэлийн дүн	386 218	387 453	411 420	414 292	412 527	431 000
Чингэлтэй	40 548	40 017	39 345	39 113	38 413	37 249
Багануур	8 514	8 569	8 133	8 328	8 557	8 662
Багахангай	1 196	1 272	1 131	1 185	1 222	1 230
Баянгол	58 756	59 536	62 976	63 079	62 784	65 543
Баянзүрх	94 971	95 714	104 764	105 791	104 881	113 245
Налайх	10 547	10 606	10 248	10 388	10 263	10 510
Сонгиохайрхан	86 212	84 236	93 521	94 132	90 231	91 815
Сүхбаатар	38 272	38 563	40 061	39 507	39 302	38 782
Хан-Уул	47 202	48 940	51 241	52 769	56 874	63 967




ХҮСНЭГТ 11. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, хороогоор, оноор

Захиргаа	2017	2018	2019	2020	2021	2022
Дүүргийн дүн	40 548	40 017	39 345	39 113	38 413	37 246
1 -р хороо	936	931	922	921	909	881
2 -р хороо	978	924	993	975	962	940
3 -р хороо	1 632	1 703	1 669	1 661	1 599	1 571
4 -р хороо	1 304	1 394	1 305	1 275	1 253	1 246
5 -р хороо	1 286	1 245	1 221	1 209	1 187	1 164
6 -р хороо	2 005	2 035	2 314	2 310	2 322	2 367
7 -р хороо	3 376	3 282	3 250	3 250	3 268	1 757
8 -р хороо	1 178	1 165	1 068	1 034	983	940
9 -р хороо	1 740	1 747	1 778	1 716	1 689	1 594
10 -р хороо	1 839	1 817	1 694	1 762	1 810	1 717
11 -р хороо	1 421	1 409	1 358	1 344	1 325	1 249
12 -р хороо	3 727	3 662	3 523	3 495	3 480	1 627
13 -р хороо	2 004	1 952	1 961	1 936	1 870	1 761
14 -р хороо	1 944	1 981	1 781	1 810	1 769	1 674
15 -р хороо	2 387	2 223	2 207	2 205	2 143	2 094
16 -р хороо	2 992	3 189	3 291	3 274	3 067	1 979
17 -р хороо	3 872	3 715	3 640	3 563	3 543	2 131
18 -р хороо	2 701	2 497	2 419	2 427	2 325	2 220
19 -р хороо	3 226	3 146	2 951	2 946	2 915	2 014
20-р хороо	-	-	-	-	-	1 392
21-р хороо	-	-	-	-	-	1 728
22-р хороо	-	-	-	-	-	1 039
23 -р хороо	-	-	-	-	-	1 263
24 -р хороо	-	-	-	-	-	898


Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоо 2022 онд 902 болж өмнөх оноос 287 (46.6%) хүнээр өссөн байна. Гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн нийт өрхийн 895 (99.2%) нь гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн хос байгаа бол 7 (0.8%) нь гэрлэлтээ дахин сэргээсэн хос байна.

Гэрлэлтээ батлуулсан хүний 55.1 хувь нь 25-34 настай, 46.1 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд байна.

ЗУРАГ 8. ГЭРЛЭСЭН ХОС, НАСНЫ АНГИЛЛААР, хувиар




ЗУРАГ 9. ГЭРЛЭСЭН ХОС, БОЛОВСРОЛЫН, түвшнээр



Зураг10. Гэрлэлтээ цуцалсан хос, хамт амьдарсан жилээр, хувиар

Шүүхийн шийдвэрээр 289 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 75 буюу 35.0 хувиар өссөн байна. Гэрлэлтээ цуцлуулсан хосын 42.6 хувь нь 30-39 настай, 20.1 хувь нь 10-14 жил хамт амьдарсан, 25.2 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Өндөр настай ганц бие өрх 2022 оны жилийн эцсийн байдлаар 1090 болж өмнөх оны мөн үеэс 536 (96.8%) өссөн байна. 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 1395 бүртгэгдэж өмнөх оноос 746 (34.8%) өрхөөр буурсан байна. Мөн өрх толгойлсон хүн 2296 болж өмнөх оноос 204 (8.2%) буурсан байна.



Дүүргийн нийт өрхийг сууцны төрлөөр нь авч үзвэл 8279 өрх буюу 22.2 хувь нь нийтийн орон сууцанд, 519 өрх буюу 1.4 хувь нь бие даасан тохилог сууцанд, 18518 өрх буюу 49.7 хувь нь сууцны тусдаа байшинд, 9904 өрх буюу 26.6 хувь нь монгол гэрт амьдарч байгаа бол 16 өрх буюу 0.04 хувь нь өөрсдийн гэсэн орон гэргүй амьдарч байна.

ХҮСНЭГТ 12. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, хороогоор, 2022 он

Захиргаа	Нийт өрхийн тоо	Нийтийн орон сууцанд амьдардаг	Тусдаа тохилог орон сууц амьдардаг	Байшинд амьдардаг	Монгол гэрт амьдардаг	Орон гэргүй /тэнэмэл/
Дүүргийн дүн	37 246	8 279	519	18 518	9904	16
1 -р хороо	881	876	-	-	-	-
2 -р хороо	940	940	-	-	-	-
3 -р хороо	1 571	1 571	-	-	-	-
4 -р хороо	1 246	1 241	-	-	-	-
5 -р хороо	1 164	1 164	-	-	-	-
6 -р хороо	2 367	2 367	-	-	-	-
Байшин хорооллын дүн	8 159	8 159	-	-	-	-
7 -р хороо	1 757	-	38	1 020	698	1
8 -р хороо	940	6	23	675	235	1
9 -р хороо	1 594	-	99	1078	417	-
10 -р хороо	1 717	114	-	799	803	1
11 -р хороо	1 249	-	21	879	348	1
12 -р хороо	1 627	-	-	997	630	-
13 -р хороо	1 761	-	64	1 411	285	1
14 -р хороо	1 674	-	25	1 004	645	-
15 -р хороо	2 094	-	109	1 557	428	-
16 -р хороо	1 979	-	-	1 318	661	-
17 -р хороо	2 131	-	22	1 577	531	1
18 -р хороо	2 220	-	8	1 500	712	-
19 -р хороо	2 014	-	-	1 152	861	1
20-р хороо	1 392	-	39	689	661	3
21-р хороо	1 728	-	48	853	827	-
22-р хороо	1 039	-	4	597	435	3
23-р хороо	1 263	-	19	690	554	-
24-р хороо	898	-	-	722	173	3
Гэр хорооллын дүн	29 087	120	519	18 518	9904	16

2022 оны жилийн эцсийн тооллогоор 17 хорооны 62 өрхийн 516 тэжээвэр амьтад тоологдсон нь өнгөрсөн оны мөн үеэс 29.2 хувиар буурсан байна. Тооллогоор 307 тахиа, 13 галуу, 128 тагтаа, 12 цацагт хяруул, 56 туулай тоологдсон байна.





ХҮСНЭГТ 13. ТЭЖЭЭВЭР АМЬТАН ТӨРЛӨӨР, хороогоор, 2022 он

Хороо	Бүгд	Тахиа	Галуу	Тагтаа	Цацагт хяруул	Нугас	Туулай
Дүүргийн дүн	202	81	2	88	9	-	10
7-р хороо	33	23	-	-	-	-	10
9-р хороо	6	3	-	3	-	-	-
10-хороо	6	-	-	6	-	-	-
11-р хороо	49	15	-	24	-	-	10
12-р хороо	15	-	-	15	-	-	-
13-р хороо	13	5	2	6	-	-	-
14-р хороо	30	21	-	-	9	-	-
15-р хороо	22	-	-	20	-	-	2
16-р хороо	28	14	-	14	-	-	-

Ойлголт, тодорхойлолт

Өрх: Ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан, зарим гишүүд нь огт хамааралгүй, эсвэл эдгээрийн аль алинаас бүрдсэн байж болно. Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.⁶

Өрхийн тэргүүн: Өрхийн гишүүд хэнийгээ тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Гэхдээ өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-гаас дээш насны бөгөөд өрхийн бусад гишүүд өрхийн тэргүүлэгчээр өргөмжилсөн хүн байна. Хэрвээ өрхийн тэргүүлэгчээ тодорхойлж чадахгүй бол тухайн өрхийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа хүнийг өрхийн тэргүүнээр авч үзэж болно.⁶

Өрхийн ам бүлийн гишүүд: Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой болон холбоогүй, нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тухайн өрх айлд өрхийн ам бүлийн гишүүдээс нь гадна түүнд хамрахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно. Түүнээс гадна өөр газар амьдарч, ажиллаж (хугацаат цэргийн алба хааж байгаа, өөр аймаг, нийслэлд сурч байгаа оюутан сурагчид, түр хугацаагаар гадаад, дотоодод явагчид гэх мэт) байгаа өрхийн ам бүлийн гишүүд орно.⁶

Өрхийн ам бүлийн дундаж тоо: Нэг өрхөд ногдох өрхөд харьяалагдан амьдардаг хүний тоог илэрхийлнэ.³

Гэр бүл: Голдуу гэрлэлт, төрөлт эсвэл үрчлэлтээр холбогдон хамтдаа амьдарч буй хоёр ба түүнээс олон тооны хүнийг хэлнэ. Гэр бүл нь төрсөн ах, эгч, дүүс, ураг төрлийн бусад холбоотой хүмүүс, гэр бүл тэдгээрийн үр хүүхдээс бүрдэж болно.³

Гэрлэлтийн байдал: Гэр бүлийн тухай Монгол Улсын хууль болон уламжлалт ёсны дагуу гэрлэлтийн байдлыг дараахь төрлүүдээр тодорхойлно.³

Огт гэр бүл болоогүй: Арван тав, түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

Гэрлэсэн гэдэгт дараахь хүн амыг хамруулна.

- I. **Батлуулсан гэр бүлтэй:** Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг хэлнэ.
- II. **Батлуулаагүй гэр бүлтэй:** Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хэлнэ.

Бэлбэсэн: Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй бол бэлбэсэн гэж үзнэ.

Тусгаарласан: Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй, тусдаа амьдарч байгаа хүмүүсийг тусгаарласан гэж үзнэ.

Цуцалсан: Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй байгаа хүмүүсийг гэр бүлээ цуцалж салсан гэж үзнэ.

Гэрлэлтийн голч нас: Нийт гэрлэсэн хүн амын тоог анх гэрлэсэн насаар нь таллан хуваах үеийн нас болно. Энэ нь тухайн онд гэрлэсэн хүн амын тал хувь нь голч наснаас өмнөх насандаа, үлдсэн тал хувь нь түүнээс хойших насандаа гэрлэж байгааг харуулна.^{1,5}

Гэрлэлтийн дундаж нас: Тухайн улсын хүн ам төрснөөсөө хойш дунджаар хэдэн жилийн дараа гэрлэж байгааг харуулна^{1,5}

Тооцох арга зүй: Насны бүлэг дэх гэрлэсэн хүн амын тоог гэрлэх үеийн насны бүлгийн дундаж утгаар үржүүлж, нийлбэрийг гэрлэгчдийн нийт тоонд харьцуулж тооцно.

$$\text{ГДН} = \frac{\sum(\tilde{A}_i * \text{НБД}_i)}{\text{ГТ}}$$

ГДН - Гэрлэлтийн дундаж нас

$\tilde{A}_i$ - i насны бүлгийн гэрлэсэн хүн амын тоо

НБД _{i} - i гэрлэх үеийн насны бүлгийн дундаж утга

ГТ - Гэрлэгчдийн нийт тоо

Гэрлэлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.^{1,5}

Тооцох арга зүй: Тухайн жилийн гэрлэлтийн нийт тоог (анхны болон дахин гэрлэлт орсон) хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ.

$$\text{ГЕК} = \frac{\text{ГТ}}{\text{ХА}_{(\text{дун})} * 1000}$$

ГЕК - Гэрлэлтийн ерөнхий коэффициент

ГТ - Тухайн жилийн гэрлэлтийн нийт

тоо $\text{ХА}_{(\text{дун})}$ - Хүн амын жилийн дундаж

тоо

Гэрлэлтийн тусгай коэффициент: Тухайн жилийн 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.^{1,5}

Тооцох арга зүй: Тухайн жилийн гэрлэлтийн нийт тоог 15 буюу түүнээс дээш насны хүн амын тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ.

$$\text{ГТК} = \frac{\text{ГТ}}{\text{ХА}(15+)} * 1000$$

ГТК - Гэрлэлтийн тусгай коэффициент

ГТ - Тухайн жилийн гэрлэлтийн нийт

тоо $\text{ХА}(15+)$ - 15 ба түүнээс дээш насны

хүн амын тоо



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН


Хайх ...



СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



/StatisticMGL

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

Танилцуулга хянасан:

Д.Мөнхзул

Танилцуулгыг боловсруулан:

Г.Пүрэвсүрэн